



МОНГОЛЫН МАТЕРИАЛ СУДЛАЛ
ГАГНУУРЫН НИЙГЭМЛЭГ

МОНГОЛЫН МАТЕРИАЛ СУДЛАЛ ГАГНУУРЫН НИЙГЭМЛЭГ-ийн 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 2 дугаар сарын 10.

Нэг. ММСГН-ээс тайлангийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын талаар.

А. Зохион байгуулалт, сурталчилгаа, сургалт, атестатчлалын чиглэлээр

1. ММСГН-ээс 2019 онд хийж гүйцэтгэх 26 зүйл бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа.
2. Нийгэмлэгийн үйл ажиллагааны тайланг „Төрийн бус байгууллагын тухай” хуулийн дагуу Улсын Бүртгэлийн Газарт дараа оны 2-р сарын 15-ны дотор гарган өгч ажилласан ба татвар, нийгмийн даатгалын төлбөр, тооцоо, тайланг хуулийн хугацаанд хэрэгжүүлж ажиллав.
3. ММСГН-ийн www.mmsws.mn веб сайтыг байнга ажиллуулж мэдээллийг шинэчилж ирлээ.
4. Нийгэмлэгийн үйл ажиллагаа, үндсэн зорилго, хэрэгжүүлж буй арга хэмжээ, гагнуурчин мэргэжлийн онцлог, ач холбогдол зэргийг байгууллага, ААН, хувь хүмүүст ойлгуулах, сурталчлах ажлыг урьдын адил гүйцэтгэж ирлээ.
5. ММСГН т гагнуур, огтлогооны чиглэлээр хандаж туслалцаа хүссэн, зөвлөгөө авах, гагнуурын ажлын чанар шалгуулах, холбоо тогтоох, гагнуурчин бэлдэх, шалгуулах, зэрэглэл тогтоох, сургалтын талаар зөвлөгөө авах зэрэг хүсэлтүүдийг хүлээн авах, туслалцаа дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллаж байлаа.
6. Эрдэс Баялаг Эрчим Хүчний сайдын 2010 оны 01-р сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан „Гагнуурчид болон гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлж зэрэг олгох дүрэм”-ийн дагуу ГММСҮТ, Даян ХХК, ДЦС-3 ТӨХК, Оюу толгой ХК, REDPATH, MCS property, Xacy- Мегаватт ХХК зэрэг 22 компани 296 гагнуурчнаас аттестатчлалын шалгалт авч, үнэмлэх, сертификат 2 жилийн хугацаатай олгов.
7. Гагнуурын инженер техникийн ажилтан 9 хүнд, Гагнуурын оёдлын гадна дотоод гэмтэл согогийг судлах” сэдвээр сургалт зохион байгуулав.

8. МСҮТөв болон Политехник коллежийн 23 багш наарт „Дэлхийн ур чадварын тэмцээний үнэлгээ болон радиограф, хэт авиаагаар гагнуурын оёдлын гэмтэл согогийг үнэлэх” талаар сургалт, семинар зохион байгуулав.
9. Өмнөговь аймгийн ПТК-ийн багш наарт 10 хоногийн, Чойбалсангийн ДЦС-ын гагнуурчдад 4 хоногийн гагнуурын сургалт тус тус зохион байгууллаа.
- 10.ДЦС- 4 ТӨХК-ы Гагнуурчид, огтлогоочдын өдөрлөг 11-р сард болж,, ММСГН-ийн үйл ажиллагаа, зорилго, зорилтын талаар” нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн илтгэл тавьж оролцлоо.
- 11.2019 оны 4-р сард БНСУ-д 20 хоногийг дадлага сургуулилтыг ДУЧТ-д оролцох Т.ОюунЭрдэнэ, эксперт С.Батсайхан нар хийсэн. Уг арга хэмжээ Монгол болон БНСУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу ХНХЯ, Hyundai Heavy Industry хооронд зохион байгуулагдсан.
- 12.Нийгэмлэгийн гишүүн С.Батсайхан ОХУ-ын стандарт болох „Типовая инструкция по контролю металла и продлению срока службы основных элементов котлов, турбин и трубопроводов тепловых электростанций. Технические требования” буюу Дулааны цахилгаан станцын зуух, турбин, шугам хоолойн металд хяналт тавих, ашиглалтын хугацааг сунгах. Техникийн шаардлага “ гэсэн 130 хуудас материалыг ДЦС- 4 ТӨХК-ы захиалга, дэмжлэгээр орчуулсан. Шүүмж, дүгнэлтийг МУ-ын зөвлөх инженер Н.Мягмарсүрэн / ММСГН/ бичсэн. Уг материал Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, ЭХЯ-ны ШУТЗөвлөлийн хурлаар орж дэмжигдэн, Стандартчлал Хэмжил Зүйн Газраар оруулж салбарын стандарттаар батлуулахаар болсон.
- 13.Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын гагнуурын мэргэжлийн сургалтын чанарыг сайжруулах, мэргэжлийн гагнуурын багш бэлтгэх, хөдөлмөрийн зах зээл буюу ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн гагнуурчин бэлтгэх, гагнуурын мэргэжлийг олон нийтийн дунд сурталчлах зорилгын хүрээнд ХНХЯамны харьяа Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний төв, ММСГНийгэмлэг, Өмнөговь аймаг дахь Политехникийн коллеж, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг/GIZ/- ийн “Түншлэлд сууринласан техникийн болон мэргэжлийн боловсрол сургалт төсөл” зэрэг Талууд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг 2019 оны 5-р сарын 17-нд байгуулав.

Б. Үзэсгэлэн яармаг, мэргэжлийн тэмцээн уралдаан зохион байгуулсан талаар

1. 2019 оны 11-р сард АНУ-ын Чикаго хотод болсон Гагнуур оттогооны олон улсын үзэсгэлэн FABTECH-2019”үзэсгэлэн яармагт Монголын мэргэжлийн төлөөллийг оролцуулах ажлыг зохион байгуулж, ДЦС- З ТӨХК, Зэт Эм И ХХК-ийн нийт 3 гагнуурын ИТА-ууд оролцсон.

2. Гагнуурчдын ур чадвар-2019” тэмцээнийг 5-р сарын 3-6 өдрүүдэд ГММСҮТ дээр зохион байгуулав.

Гагнуурын ур чадварын энэ тэмцээнийг Дэлхийн ур чадварын тэмцээн “WORLD SKILLS -2019”-ийн оролцогчийн бэлтгэлийг хангах, өрсөлдөөнийг бий болгох зорилгоор явуулсан. Тэмцээнд “Монгол ур чадвар- 2014” тэмцээний тэргүүн байр, олон улсын тэмцээний шагналт,

Сан-Паологийн ДУЧ- ын 43 дах тэмцээний оролцогч Л.Ганцож /МИАТ/

Монгол ур чадвар- 2016” тэмцээний тэргүүн байр, ОУ-ын тэмцээний алт, мөнгө, хүрэл медальт Д.Нямрагчаа /ГММСҮТ/, “Монгол ур чадвар-2017” тэмцээний тэргүүн байр, ОУ-ын тэмцээний алтан медальт, Абу-Дабигийн ДУЧ- ын 44 дэх тэмцээний оролцогч Ж.Жанлав-Ойдов / Оюутолгой ХХК/, Монгол ур чадвар-2019” тэмцээний тэргүүн байр, ОУ-ын тэмцээний алт, хүрэл, тусгай байрын шагналт, Казаны ДУЧ- ын 45 дах тэмцээний оролцогч Т.Оюун-Эрдэнэ /ГММСҮТ/, Монгол ур чадвар- 2018” тэмцээний дэд байр, ОУ-ын тэмцээний мөнгөн медальт, МУ-ын ерөнхийлөгчийн шагналт Э.Уужимсэтгэлт /Мон-Сол. ПК/ нар оролцов.

Тэмцээнд Т.Оюун-Эрдэнэ түрүүлж Д.Нямрагчаа удаалав . Тэмцээний шагналын сан 1.5 сая төг.

Тэмцээний үеэр „МУЧ- 2019” шилдэг оролцогч Т.Оюун-Эрдэнэ, Э.Уужимсэтгэлт нарт тус бүр 500000 төгрөгийн гагнуурын багаж, хэрэгслийг Үнэлгээний Төвийн дарга Батдорж гардуулсан.

Мөн бүх оролцогчийг ОТ ХХК тус бүр 100 ам. долларын гагнуурын америк багаар урамшууллаа.

Тэмцээний үеэр MCYT-ийн багш нарт 2 өдөр, 8 цагийн гагнуурын үнэ төлбөргүй хичээл /Эхний өдөр 22, дараагийн өдөр 17 хүн оролцсон/ зааснаас гадна гагнуурын тоног төхөөрөмжийн үзэсгэлэн гаргав.

3. ОХУ-ын Казань хотод ОХУ-ын мэргэжлийн ур чадварын үндэсний 7 дахь удаагийн тэмцээн 5-р сарын 20-23 өдрүүдэд болж, Т.Оюун-Эрдэнэ, эксперт С.Батсайхан нар оролцож даалгавраа бүрэн биелүүлсэн. ДУЧ-ын тэмцээний бэлтгэл ажлын нэг болсон.

4. ММСГН-ээс ОХУ-ын Екатеринбург хотод 9-р сард болсон гагнуурчдын ур чадварын ОУ-ын Hitech-2020 тэмцээнд Хасу-Мегаватт ХХК-ийн гагнуурчин Т.Оюун-Эрдэнийг оролцуулах ажлыг зохион байгуулав. Т.Оюун-Эрдэнэ амжилттай оролцож 2-р байр эзэлсэн. Т.Оюун-Эрдэнийн онгоцны зардлыг Хасу-Мегаватт ХХК, эксперт С.Батсайханы онгоцны зардлыг ММСГН гаргасан болно. Бусад зардлыг ОХУ-ын тал даасан.
5. Хоёр жил тутам болдог Дэлхийн ур чадварын „WORLD SKILLS-2019” 45 дахь удаагийн тэмцээн Казань хотод болж ГММСҮТ-ийн суралцаагч Т.Оюун-Эрдэнэ оролцов. Тэмцээн 8-р сарын 23-26 өдрүүдэд болж Т.Оюун-Эрдэнэ 38 орны оролцогчтой өрсөлдөн 711 оноо авснаар 12-р байранд орлоо. Монголоос оролцсон 8 мэргэжлийн хамгийн шилдэг „Best of nation” болж, гагнуурын ур чадварын шилдгийн, Medalion for excellence” шагнал хүртсэн. Өмнөх ДУЧ-ын тэмцээний оноог 11-ээр нэмж, байраа 5 аар урагшлуулав. ММСГН-ээс энэ томоохон тэмцээнд хөндлөнгийн ажиглагчаар инженер О.Мөнхтөгс, мэргэжилтэн Н.Ганхуяг нарын зардлыг дааж явуулах ажлыг зохион байгуулсан нь мэдлэг, туршлага хуримтлуулсан үр дүнтэй ажил боллоо.
6. Хоёр жил тутам зохион байгуулдаг Гагнуурчдын ур чадварын улсын аваргын тэмцээнийг 2019 оны 12-р сарын 2-6 өдрүүдэд ГММСҮТөв дээр зохион байгуулж явууллаа. Тэмцээний журмыг урьдчилан гаргаж Удирдах Зөвлөлийн даргаар батлуулан нийгэмлэгийн вэб сайтад байршуулан мөн томоохон компани албан газруудад албан бичгээр мэдэгдэж ажиллав. Тэмцээний бэлтгэл ажлын төлөвлөгөө төсөв гарган хэрэгжилтийг хангаж ажиллаа. Батлагдсан журмын дагуу тэмцээнийг цахилгаан гар нуман гагнуур (111/SMAW), хагас автомат (135/GMAW), аргон гагнуур (141/GTAW), хийн гагнуур (311/OFW), бүтээгдэхүүн хийх угсралт (111/SMAW, 135/GMAW, 141/GTAW, 136/FCAW) гэсэн 5 төрлөөр зарлаж явууллаа. Харин хийн гагнуурын төрөлд оролцогчид журманд заасан тоонд хүрээгүй тул энэ төрлөөр тэмцээн явуулаагүй.

Энэ удаагийн тэмцээн дараах онцлогуудтай болж өнгөрлөө

- Ахуудаа хийцийн төрлөөр өрсөлдөв
- Хамгийн сүүлийн үеийн Panasonic, Kettprpy гагнуурын шинэ аппарат болон БНСҮ-ын CHO SUN брэнд электрод ашиглалаа.
- Залуу гагнуурчдын ур чадвар ихээхэн дээшилсэн байлаа.

Тэмцээнд давхардсан тоогоор 32 компани байгууллагын нийт 164 гагнуурчин өрсөлдөж Цахилгаан гануурын төрөлд (74) Х.Бямбажав / MCS ХХК/111.5 оноогоор 1-р байр, Ж.Жанлав-Ойдов Оюутолгой ХХК 93.5 оноо 2-р байр, М.Ганхуяг ДЦС З ТӨХК 93.0 оноо 3-р байр, Аргон гагнуурын төрөлд (39) С.Баасанхүү / Хасу-Мегаватт ХХК/ 188 оноо 1-р байр, Ж.Жанлав-Ойдов /Оюутолгой ХХК/ 182 оноо 2-р байр, Т.Оюун-Эрдэнэ /Хасу-Мегаватт ХХК/ 173 оноо 3-р байр, Хагас автомат төрөлд (37) Б.Өлзийбүян /Хасу-Мегаватт ХХК/ 149.5 оноо 1-р байр, М.Ганхуяг /ДЦС-З ТӨХК/ 128.5 оноо 2-р байр, Б.Занданбат /Гурван мөнх ХХК/ 126 оноо 3-р байр, Хийц угсралт төрлөөр (14) Д.Нямрагчаа /Хасу-Мегаватт ХХК/ 48 оноо 1-р байр, Т.ОюунЭрдэнэ /Хасу-Мегаватт ХХК/ 38 оноо 2-р байр, Ж.Жанлав-Ойдов /Оюутолгой ХХК/ 34 оноо 3-р байр тус тус эзэллээ. Төрөл тус бүрт эхний 3 байр эзэлсэн нийт 12 гагнуурчинд 300000-1000000 төгрөгийн шагнал олгов.

Журмын дагуу болзол хангасан гагнуурчдыг 2020 онд БНХАУ-д болох гагнуурчдын олон улсын ARC CUP-2020 эмцээнд оролцох эрхийн бичгээр шагналаа.

Тэмцээний үеэр гагнуурын тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж МАОЭХолбоо ДЦС-2,3,4, Амгалан ДС, МЭЗ ХХК, ДБЭХС ТӨХК удирдлагуудыг урилгаар оролцуулах ажлыг хийж гүйцэтгэв .

Хоёр. Нийгэмлэгийн зүгээс цаашид анхаарах ажил

1. Материал судлалын чиглэлээр хийх ажил сул байна
2. Азийн Гагнуурын Холбоотой харилцаагаа гүнзгийрүүлж хурал зөвлөгөөнд нь оролцох АГХ-ны шалгалт авах тогтолцоог нэвтрүүлэх чиглэлд ахиц гаргах
3. БНХАУ-д болох гагнуурчдын ур чадварын ARC CUP-2020 олон улсын тэмцээнд гагнуурчдаа бэлдэж оролцох
4. Танилцуулга брошур хийж, нийгэмлэгээ сурталчлах

ММСГН- ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг 2019 оны 12-р сарын эцсээр нийгэмлэгийн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулж , "Хангалттай" үнэлгээ авсан.

ММСГН- ийн хаяг:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эрчим хүчний 50-р гудамж, Төмөр хийцийн үйлдвэрийн байр 105 тоот.

ММСГН-ийн үүсгэн байгуулагчид:

Ж.Түмэн-Аюуш. Удирдах Зөвлөлийн дарга. Утас: 99117359

Гэрийн хаяг:

Улаанбаатар хот, Хануул дүүрэг, 11-р хороо, 2-р хэсэг, Лагшири Зайсан
Виллаж, 6-р байр, 5 тоот

Б.Зулбаяр. Удирдах зөвлөлийн гишүүн. Утас: 99109486

Гэрийн хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороолол, 9-р байр, 54 тоот

Тайлан бичсэн:



/Н.Мягмарсүрэн/

ММСГН-ийн гүйцэтгэх захирал